

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөөгөө, гүйцэтгэл .....	17
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Л.ЦАНЛИГРЭНЧИН ТАНАА

2020.03.18 № 06/801  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн захирал Д.Цанлигрэнчин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг заавар журмын дагуу хийх, дулааны төлбөрийн найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах, программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Д.Нямдорж, аудитор Л.Хаш-Эрдэнэ, туслах аудитор Ө.Рагчаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн зорилго нь “Тухайн нутаг дэвсгэртээ хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай, бүрэн ханган, эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах” гэж тодорхойлжээ.

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалттай хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь гүйцэтгэх захирлын 2019 оны А/68 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Diamond 5.0” программ хангамж ашигладаг байна.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 36,446.0 сая төгрөгөөс тооцон 364.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 368.2 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны санхүүгийн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцоолсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 370.1 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Оны эхний болон эцсийн үзүүлэлтийг харьцуулахад хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, эздийн өмчөөс бусад бүх дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

				/сая төгрөг/
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б		1	2	3=2-1
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21.8	25.7	3.9
2	Дансны авлага	774.4	1,478.3	703.9
4	Бараа материал	550.0	1,083.4	533.4
5	Үндсэн хөрөнгө	34,610.9	33,719.7	-891
6	Биет бус хөрөнгө	488.8	508.8	20.0
<b>7</b>	<b>Нийт хөрөнгө</b>	<b>36,446.0</b>	<b>36,816.0</b>	<b>370.1</b>
8	Дансны өглөг	1,009.3	1,614.0	604.8
12	Богино хугацаат зээл	-	550.0	550.0
13	Урьдчилж орсон орлого	13.6	10.4	-3.2
15	Өмч: - төрийн	33,981.5	33,981.5	-
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,155.7	3,155.7	-
17	Эздийн өмчийн бусад хэсэг	462.5	469.6	7.2
18	Хуримтлагдсан ашиг	-2,176.6	-2,965.2	-789
<b>19</b>	<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>36,446.0</b>	<b>36,816.0</b>	<b>370.1</b>

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 3.9 сая төгрөгөөр өссөн нь орон сууц, хувийн сууцны хэрэглэгчдийн авлага барагдсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 703.9 сая төгрөгөөр өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 231 дүгээр тогтоолоор баталсан дулааны эрчим хүчний тарифаар орон нутгийн төсөвт 32 байгууллагын дулааны борлуулалт, авлагыг бүртгэж тайлагнасантай холбоотой ба төсөвт байгууллагууд түлш халаалтын зардлын төсөв хуучин тарифаар батлагдсан тул төсөв хүрэлцээгүйгээс 622.5 сая төгрөгийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 533.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээтэй холбоотойгоор худалдан авсан бараа материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ. Тайлант онд 2,687.7 сая төгрөгийн бараа материал шинээр худалдаж авснаас үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд 2,154.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Мөн 2019 оноос нүүрсний өртөгт нүүрс тээврийн зардлыг шингээж бүртгэсэнтэй холбоотойгоор 1 тонн нүүрсний өртөг нэмэгдэж, түүхий эд материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 891.2 сая буурсан нь тайлант жилд байгуулсан 1,361.3 сая төгрөгийн элэгдлийн зардал гол нөлөө үзүүлж, хөрөнгө оруулалтаар худалдан авсан 553.7 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 398 дугаар тогтоолоор ЭДЦС ТӨХК-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 7.2 сая, нийт 560.9 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019 оны А-1/4249 дугаар тогтоолоор 20.4 сая төгрөгийн хөрөнгө акталж, өмнөх оны аудитын зөвлөмжөөр 140.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлж бүртгэсэнтэй

холбоотой байна. Үндсэн хөрөнгө нийт дүнгээр 2.6 хувиар буюу 891.2 сая төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгө 20.0 сая төгрөгөөр өссөн нь 25.0 сая төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авч, биет бус хөрөнгийн хорогдуулгын 4.8 сая төгрөгтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 604.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсөвт 32 байгууллага дулааны төлбөрийг хуучин тарифаар төлж, авлага барагдаагүйгээс, компанийн төлөвлөгөөт ажил, үйлчилгээ, бараа материалын төлбөрийг төлөх боломжгүй болсноос шалтгаалжээ.

Богино хугацаат зээл 550.0 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын авлага барагдаагүйгээс авсан зээлийн үлдэгдэл байна.

## 2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар тушаалаар компанийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2019 оны 260 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан байна.

2019 оны нийт орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулав.

Үзүүлэлт	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	5,477.5	5,439.4	38.1	99.3
Нийт зардал	6,464.6	6,213.8	250.8	96.1
Татварын өмнөх ашиг, алдагдал	-987.1	-774.4	-212.7	78.5
Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	1.2	1.1	0.1	91.7

Тайлант онд нийт 5,477.5 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 99.3 хувийн биелэлттэй буюу 5,439.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 38.1 сая төгрөгөөр тасарсан нь төсөвт байгууллагын болон бусад орлого 57.1 сая төгрөгөөр өсөж, айл өрх, аж ахуйн нэгжийн дулааны орлого 95.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Тайлант оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны нийт зардалд 6,464.6 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 6,213.8 сая төгрөгийн биелэлттэй буюу 250.8 сая төгрөгөөр зардлыг хэмнэсэн байна. Үндсэн үйл ажиллагааны зардлын хэмнэлт нь нүүрс, нүүрс тээврийн зардал 121.0 сая, цалингийн зардал 34.1 сая, элэгдлийн зардал 11.4 сая, сургалтын зардал 16.0 сая, бусад зардлыг 68.3 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны алдагдал 987.1 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 774.4 сая төгрөгийн биелэлттэй ажиллаж, алдагдлыг 212.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд 14 горим сорил хэрэгжүүлжээ.



Аудитаар нийт 786.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 779.7 сая төгрөгийн алдааг залруулж, 7.2 сая төгрөгийн алдаа болон бусад зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнээс:

- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн 2018 оны үлдэгдлийг 2 дахин нэмэгдүүлсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгын 14.2 сая төгрөгийг бүртгэж тайлагнаагүй нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангахгүй, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” -ын 4-д “Санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгалах” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүү, татварын тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Тайлант оны 2 дугаар улиралд зарцуулсан 5,645 тонн буюу 214.4 сая төгрөгийн нүүрсний орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан бэлтгээгүй, зөвхөн сард нэг удаа бараа материалын товчоо тайланд нэгдсэн дүнгээр орлого, зарлагын гүйлгээг бүртгэсэн, 3 дугаар сард үйлдвэрлэлд зарцуулсан 132.9 сая төгрөгийн нүүрсний зарцуулалтыг огт бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүү, татварын тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- 2019 оны эхний 9 сарын байдлаар үйлдвэрлэлд зарцуулсан нийт 11,677 тонн, 418.2 сая төгрөгийн нүүрсийг орлого авахдаа нүүрс тээврийн хөлсийг нь өртөгт шингээгээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлагналын үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй НББОУС 2-10-д “Бараа материалын анхдагч үнэлгээ-Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно”, гүйцэтгэх захирлын 2019 оны А/68 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Бараа материалын өртөгт түүнийг худалдан авсан үнэ болон олж бэлтгэхтэй холбогдон гарсан үйлчилгээний төлбөр, тээврийн зардал, импорт гаалийн ба онцгой татвар, худалдааны шимтгэл, барааг хүлээн авах ачиж буулгах зардал, хадгалахтай холбогдож гарсан зардлыг оруулах бөгөөд санхүүгийн тайланд өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар оруулна” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүү, татварын тайланд алдааг залруулга хийлгэсэн.

- Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 5,439.4 сая төгрөгөөр бүрдүүлж, 38.1 сая төгрөгөөр тасалдуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 1/3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалтыг зөрчсөн, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн “Эздийн өмчийн бүртгэл, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, нүүрсний зарцуулалтын бүртгэлийг сайжруулах” тухай 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, ЭХЗХ-ны баталсан үнэ тарифын дагуу тооцсон дулааны төлбөрийн авлагыг барагдуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тус байгууллагад гүйцэтгэх захирлаар 2018 онд ажиллаж байсан Д.Мөнхсайхантай холбоотой 1.6 сая төгрөгийн зөрчилд тогтоосон нөхөн төлбөрийн актыг биелүүлээгүй. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “төрийн аудитын байгууллагаас тавьсан албан САГ-2020/74/СТА-ТӨҮГ

шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй ...”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх ...” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 7.2 сая төгрөгийн алдаа болон бусад зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

ЭХЗХ-ны 2017 оны 190, 2018 оны 231 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг тус тус шинэчлэн баталсан байна. Тус компани шинэчлэгдсэн тарифаар нийт хэрэглэгчдээс дулааны борлуулалтын авлагыг бүртгэж тайлагнасан байна. Гэтэл орон нутгийн төсвөөс санхүүждэг 32 төсөвт байгууллага хуучин тарифаар дулааны зардлын төсөв нь батлагдсанаас дулааны төлбөрийг дутуу шилжүүлснээс 2017-2019 онд 1,475.7 сая төгрөгийн найдваргүй авлага үүсэж, хэрэгжээгүй борлуулалтад ногдох 147.6 сая төгрөгийн НӨАТ-ын өглөг бүртгэж тайлагнасан анхаарал татахуйц асуудлыг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасны дагуу 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар болон shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2019 онд 6 нэр төрлийн мэдээллийг жил, сар бүрийн давтамжтайгаар 62 удаа мэдээлэхээс 55 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 7 мэдээллийг хугацаа хожимдуулж мэдээлсэн байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 заалт бүхий 1 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 1 акт, нийт 8 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, аудитаар эздийн өмчийн бүртгэл, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, нүүрсний зарцуулалтын бүртгэлийг сайжруулах 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 62.5 хувьтай байна.

Албан шаардлагын тухайд 3 заалтыг хэрэгжүүлж, ЭХЗХ-ны баталсан үнэ тарифын дагуу тооцсон авлагыг барагдуулах заалт хэрэгжээгүй, 1 төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Тус байгууллагад гүйцэтгэх захирлаар 2018 онд ажиллаж байсан Д.Мөнхсайхан нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр 1.6 сая төгрөгийн урамшуулал өөртөө тооцож авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон боловч төлбөрийг барагдуулаагүй байна. Иймд актын төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэхийг компанийн удирдлагад хариуцуулав.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 7.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 368.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

ТӨБЗГ-ын 2019 оны 398 дүгээр тогтоолоор ЭДЦС ТӨХК-с үнэ төлбөргүй шилжиж ирсэн 7.2 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашиныг бүртгэхдээ үндсэн хөрөнгө, эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, хэмжилт зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалт, Сангийн сайдын 2013 оны 269 дугаар тушаал, гүйцэтгэх захирлын 2019 оны А/68 дугаар тушаалыг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хөрөнгийн орлого буруу бүртгэгдэж, тайлант үеийн үр дүнд нөлөөлөх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийн орлогыг заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 202 тоот албан бичгээр хүлээн зөвшөөрч залруулах бичилтийг 2020 оны 1 дүгээр улиралд хийхээр тайлбар ирүүлсэн.

#### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Тус компанийн үндсэн хэрэглэгч болох орон нутгийн төсвийн 32 байгууллагын дулааны зардлын төсөв шинэ тарифаар батлагдаагүйгээс төлбөрийг дутуу шилжүүлж 2019 онд 622.4 сая төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн

байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**3.2.2 Эрсдэл:**

Орлого дутагдаж төлөвлөгөөт ажил үйлчилгээ, нөөц хөрөнгө тасалдаж, станцын үйл ажиллагааг доголдох.

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж байгаа тул авлагыг барагдуулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, барагдуулах.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

**3.3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

**3.3.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлийг иж бүрэн толилуулахгүй алдаатай, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн аудитын газар, шилэн дансны системтэй цахимаар мэдээлэл солилцох боломжгүй, цахим тайлангийн нэгтгэлд мэдээлэл татан оруулах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг төлөвлөгөөтэй харьцуулж, шинжилгээ хийх боломжгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-тай нийцэхгүй байна.

**3.3.2 Эрсдэл:**

Тайлан мэдээ хугацаа алдаж гарах, буруу илэрхийлэгдэх.

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Хөрөнгө</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21,779,327.02	25,720,121.76
1.1.2	Дансны авлага	774,310,633.00	1,477,627,020.61
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	138,085.70	713,304.81
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	549,979,335.00	1,083,383,486.32
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,346,207,380.72</b>	<b>2,587,443,933.50</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	34,610,938,797.47	33,719,738,572.23
1.2.2	Биет бус хөрөнгө	488,810,763.86	508,842,004.73
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>35,099,749,561.33</b>	<b>34,228,580,576.96</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,445,956,942.05</b>	<b>36,816,024,510.46</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	766,573,125.68	1,383,483,892.77
2.1.1.2	Цалингийн өглөг	12,186.00	0.00
2.1.1.3	Татварын өр	241,164,473.26	230,219,217.24
2.1.1.4	НДШ-ийн өглөг	84,040.00	311,406.13
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	550,000,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	13,593,529.50	10,426,360.00
2.1.1.9	Нөөц /богино хугацаат өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,443,671.58	-
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,022,871,026.02</b>	<b>2,174,440,876.14</b>
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,022,871,026.02</b>	<b>2,174,440,876.14</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	33,981,526,313.42	33,981,526,313.42
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,155,701,953.17	3,155,701,953.17
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	462,450,000.00	469,600,866.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,176,592,350.56)	(2,965,245,498.91)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>35,423,085,916.03</b>	<b>34,641,583,634.32</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>36,445,956,942.05</b>	<b>36,816,024,510.46</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>5,077,397,920.50</b>	<b>5,405,768,512.28</b>
2	Борлуулалтын өртөг	5,087,776,704.60	5,909,256,473.20
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(10,378,784.10)</b>	<b>(503,487,960.92)</b>
5	Хүүгийн орлого	249,258.17	251,339.34
8	Бусад орлого	37,328,806.70	33,368,264.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	12,768,287.90	22,264,763.37
10	Ерөнхий ба удирдлагын зардал	67,085,593.09	138,183,666.63
12	Бусад зардал	159,531,906.15	144,122,719.73
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(212,186,506.37)</b>	<b>(774,439,507.31)</b>
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(212,186,506.37)</b>	<b>(774,439,507.31)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(212,186,506.37)</b>	<b>(774,439,507.31)</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(212,186,506.37)</b>	<b>(774,439,507.31)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	<b>4,927,566,856.84</b>	<b>5,314,071,878.74</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,885,777,932.74	5,296,210,363.12
1.1.4	Буцаан авсан албан татвар	37,805,235.00	9,479,789.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,983,689.10	8,381,726.62
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>	<b>4,784,320,092.27</b>	<b>5,425,348,734.34</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,059,130,389.00	1,435,336,268.07
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	392,786,094.00	496,556,421.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,573,123,000.43	1,537,642,998.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	599,932,513.00	460,505,549.41
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	680,835,757.00	952,235,543.29
1.2.7	Татварын байгуулагд төлсөн	414,518,982.00	451,654,888.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	116,520.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	63,993,356.84	91,300,544.64
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>143,246,764.57</b>	<b>(111,276,855.60)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	<b>249,258.17</b>	<b>43,181,339.34</b>
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	249,258.17	251,339.34
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>	<b>142,434,063.00</b>	<b>477,963,689.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	141,396,763.00	466,453,514.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,037,300.00	11,510,175.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(142,184,804.83)</b>	<b>(434,782,349.66)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	-	<b>550,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	550,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>550,000,000.00</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,061,959.74</b>	<b>3,940,794.74</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>20,717,367.28</b>	<b>21,779,327.02</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>21,779,327.02</b>	<b>25,720,121.76</b>



**4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>33,981,526,313.42</b>	-	-	<b>(1,836,811,226.73)</b>	32,144,715,086.69
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(127,594,617.46)	(127,594,617.46)
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	-	-	(1,964,405,844.19)	32,017,120,469.23
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(212,186,506.37)	(212,186,506.37)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	462,450,000.00	-	462,450,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	3,155,701,953.17	-	-	3,155,701,953.17
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>33,981,526,313.42</b>	<b>3,155,701,953.17</b>	<b>462,450,000.00</b>	<b>(2,176,592,350.56)</b>	<b>35,423,085,916.03</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(14,213,641.04)	(14,213,641.04)
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	(2,190,805,991.60)	35,408,872,274.99
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(774,439,507.31)	(774,439,507.31)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	7,150,866.64	-	7,150,866.64
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>33,981,526,313.42</b>	<b>3,155,701,953.17</b>	<b>469,600,866.64</b>	<b>(2,965,245,498.91)</b>	<b>34,641,583,634.32</b>

#### 4.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөөгөө, гүйцэтгэл

сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1. Нийт борлуулалт</b>	<b>5,477,530.2</b>	<b>5,439,388.1</b>	<b>(38,142.1)</b>	<b>99.3</b>
1.1. Дулааны эрчим хүч борлуулалт	5,466,530.2	5,405,768.5	(60,761.7)	98.9
Үүнээс:1.1.1. Төсвийн байгууллагаас	4,072,891.7	4,107,434.7	34,543.0	100.8
1.1.2. Аж ахуйн нэгжээс	1,051,468.3	966,994.8	(84,473.5)	92.0
1.1.3. Айл өрх, гарж, подвал	342,170.2	331,339.0	(10,831.2)	96.8
1.2. Бусад орлого	11,000.0	33,619.6	22,619.6	305.6
<b>2. Нийт зардал</b>	<b>6,464,635.5</b>	<b>6,213,827.6</b>	<b>(250,807.9)</b>	<b>96.1</b>
<b>2.1. Үйл ажиллагааны зардал</b>	<b>6,072,082.8</b>	<b>5,907,736.3</b>	<b>(164,346.4)</b>	<b>97.3</b>
2.1.1. Нүүрсний зардал	807,045.0	789,593.6	(17,451.4)	97.8
2.1.2. Нүүрс тээврийн зардал	557,721.8	454,153.9	(103,567.9)	81.4
2.1.3. Цахилгааны зардал	495,165.1	525,361.8	30,196.7	106.1
2.1.4. Усны зардал	99,769.5	74,205.5	(25,564.0)	74.4
2.1.5. Урсгал засвар Сэлбэг хэрэгсэл	243,047.4	243,340.6	293.3	100.1
2.1.7. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,378,743.8	1,367,377.3	(11,366.5)	99.2
2.1.8. Шатах тослох материалын зардал зардал	26,317.6	24,610.6	(1,707.0)	93.5
2.1.9. ХАБ, ЭА-н зардал	127,896.0	128,076.9	180.9	100.1
2.1.10. Байгаль орчныг хамгаалах зардал	19,255.0	14,398.9	(4,856.1)	74.8
2.1.11. Галын аюулаас хамгаалах зардал	2,174.0	2,199.0	25.0	101.2
2.1.12. Нийт цалингийн сан	1,834,600.2	1,803,116.4	(31,483.8)	98.3
2.1.13. Байгууллагаас төлөх ЭМ,НДШ	266,017.0	263,390.3	(2,626.7)	99.0
2.1.14. Албан томилолтын зардал	23,339.3	19,126.9	(4,212.4)	82.0
2.1.15. Бичиг хэргийн зардал	9,711.3	9,375.5	(335.8)	96.5
2.1.16. Цэвэрлэгээний зардал	9,551.4	8,376.0	(1,175.4)	87.7
2.1.17. Интернет үйлчилгээ	5,280.0	5,104.0	(176.0)	96.7
2.1.18. Шуудан,холбоо	2,166.0	1,327.6	(838.4)	61.3
2.1.19. Борлуулалт, маркетингийн зардал	17,102.6	16,767.4	(335.2)	98.0
2.1.20. Түрээс	37,363.2	31,248.8	(6,114.4)	83.6
2.1.21. Сургалтын зардал	28,520.0	12,519.7	(16,000.3)	43.9
2.1.22. Даатгалын зардал	10,009.1	12,656.9	2,647.8	126.5
2.1.23. Харуул хамгаалалт	-	-	-	
2.1.24 Нүүрс түрэх, үнс зөөх зардал	51,885.9	46,534.2	(5,351.7)	89.7
2.1.25 Бараа материал акталсан		11,430.0	11,430.0	
2.1.26. Үйл ажиллагааны бусад зардал	19,401.6	43,444.5	24,042.9	223.9
<b>2.2. ААНОАТ-аас бусад татварын зардал</b>	<b>36,830.7</b>	<b>26,154.8</b>	<b>(10,675.9)</b>	<b>71.0</b>
2.2.1. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	15,909.9	18,619.4	2,709.5	117.0
2.2.2. АТӨЯХ-ийн албан татвар	880.4	695.1	(185.3)	79.0
2.2.3. Газрын төлбөр	1,881.4	1,907.8	26.4	101.4
2.2.4. Усны ашигласны төлбөр	18,159.0	4,932.6	(13,226.4)	27.2
<b>2.3. Бүрэн өөрийн өртөг</b>	<b>6,108,913.5</b>	<b>5,933,891.2</b>	<b>(175,022.3)</b>	<b>97.1</b>
<b>2.4. ХОӨ-өөр нөхөгдөх зардал</b>	<b>355,722.1</b>	<b>279,936.5</b>	<b>(75,785.6)</b>	<b>78.7</b>
<b>3. Ашиг</b>	<b>- 987,105.3</b>	<b>-74,439.5</b>	<b>(212,665.8)</b>	<b>78.5</b>

## Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/74/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Хөвсгөл дулааны станц ТӨХК</b>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ТӨБЗГ-ын 2019 оны 398 дүгээр тогтоолоор ЭДЦС ТӨХК-с үнэ төлбөргүй шилжиж ирсэн 7.2 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашиныг бүртгэхдээ үндсэн хөрөнгө, эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн.	7.2	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Л.Цанлигрэнчин В.Мөнгөнцэцэг
2	Тус компанийн үндсэн хэрэглэгч болох орон нутгийн төсвийн 32 байгууллага шинэ тарифаар дулааны зардлын төсөв батлагдаагүй гэдэг шалтгаанаар хуучин хүчингүй болсон үнэ тарифын дагуу дулааны төлбөрөө төлдөг, тус компани нь шинээр батлагдсан үнэ тарифаар дулааны төлбөрөө нэхэмжилж, борлуулалтаа тооцон авлага бүртгэж тайлагнасан байна. Үүний улмаас 2019 онд 622.4 сая төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж байгаа тул авлагыг барагдуулах талаар шат дараалсан арга хэмжээ авах шаардлагатай байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Л.Цанлигрэнчин В.Мөнгөнцэцэг
3	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь Сангийн яам, Төрийн өмчийн бодлог зохицуулалтын газар, Төрийн аудитын газар, шилэн дансны системтэй цахимаар мэдээлэл солилцох боломжгүй, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлийг илчилж, иж бүрэн толилуулахгүй алдаатай байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Л.Цанлигрэнчин В.Мөнгөнцэцэг
4	Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, эдийн засгийн зорилтот түвшний орлогын	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан	Л.Цанлигрэнчин В.Мөнгөнцэцэг

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

	<p>төлөвлөгөөг 5,439.4 сая төгрөгөөр бүрдүүлж, 38.1 сая төгрөгөөр тасалдуулсан, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн “Эздийн өмчийн бүртгэл, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, нүүрсний зарцуулалтын бүртгэлийг сайжруулах” тухай 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, ЭХЗХ-ны баталсан үнэ тарифын дагуу тооцсон дулааны төлбөрийн авлагыг барагдуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тус байгууллагад гүйцэтгэх захирлаар 2018 онд ажиллаж байсан Д.Мөнхсайхантай холбоотой 1.6 сая төгрөгийн зөрчилд тогтоосон нөхөн төлбөрийн актыг биелүүлээгүй</p>			<p>бодогч</p>	
	<p><b>Дүн</b></p>	<p><b>7.2</b></p>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/157

Улаанбаатар хот

САГ - 00 00/74/СТА-704Г

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 5,439.4 сая төгрөгөөр бүрдүүлж, 38.1 сая төгрөгөөр тасалдуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-ийн 1/3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" заалтыг зөрчсөн байна.
2. ЭХЗХ-ны баталсан үнэ тарифын дагуу тооцсон дулааны төлбөрийн авлагыг барагдуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тус байгууллагад гүйцэтгэх захирлаар 2018 онд ажиллаж байсан Д.Мөнхсайхантай холбоотой 1.6 сая төгрөгийн зөрчилд тогтоосон нөхөн төлбөрийн актыг биелүүлээгүй. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй ...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх ..." заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх алдаа, зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цанлигрэнчин, ерөнхий нягтлан бодогч В.Мөнгөнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭЭГЧ  
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ"  
ХХК-ИЙН АУДИТОР Л.ХАШ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.ЦАНЛИГРЭНЧИН  
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ  
В.МӨНГӨНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь эхлэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцаж ажиллахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

